



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2022 оны 05 сарын 19 өдөр

Дугаар А/289

Улаанбаатар хот

Магадлан итгэмжлэл олгох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсэг, Эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэх зөвлөлийн 2022 оны 7 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн байгууллагын нэрсийг хавсралтаар баталж, батламжийг олгосугай.


2. Говьсүмбэр аймгийн Нэгдсэн эмнэлгийн бүтэц, зохион байгуулалтыг хангаж ажиллах, тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах, шинжээчдийн багаас өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлыг тасралтгүй зохион байгуулах, зөвлөмжийн дагуу хэрэгжүүлсэн ажлын тайланг 1 сарын дараа дахин ирүүлж ажиллахыг Нэгдсэн эмнэлгийн дарга /У.Ариун-Эрдэнэ/, Эрүүл мэндийн газрын дарга /Ц.Мөнх-Од/-д нарт үүрэг болгосугай.

3. Шинжээчийн багийн өгсөн зөвлөмжийн биелэлтийг 1 сарын дараа ажлын байранд очиж үнэлэх ажлыг зохион байгуулахыг Эрүүл мэндийн хөгжлийн төв /Б.Нарантуяа/-д даалгасугай.

4. Эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэх зөвлөлийн 2022 оны 5 дугаар сарын 19-ний өдрийн хурлын шийдвэрийг холбогдох эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар /П.Эрхэмбаяр/, Эрүүл мэндийн хөгжлийн төв /Б.Нарантуяа/ -д тус тус үүрэг болгосугай.

5. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /С.Төгсдэлгэр/-т даалгасугай.

САЙД



С.ЭНХБОЛД

141221392

Эрүүл мэндийн сайдын 2022 оны 05
дугаар сарын 19 - ны өдрийн 14/2022
дугаар тушаалын хавсралт

МАГАДЛАН ИТГЭМЖЛЭГДСЭН ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН НЭР

№	Эрүүл мэндийн байгууллагын нэрс	Батламжийн Дугаар	Магадлан итгэмжлэгдсэн хугацаа	Магадлан итгэмжлэл эхлэх огноо	Магадлан итгэмжлэл дуусах огноо
1.	Говьсүмбэр аймгийн Нэгдсэн эмнэлэг	150/2022	1 жил	2022.05.19	2023.05.19

---o0o0---